

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: : 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт

Хамрагдсан байгууллага: Нийслэлийн Аялал жуулчлалын газар

Улаанбаатар хот

2024 он

АГУУЛГА


ТАНИЛЦУУЛГА.....	3
ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ	3
Зорилго.....	3
Хамрах хүрээ	3
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН	4
Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар.....	
Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар.....	
Зорилт 3. Худалдан авах ажиллагааны талаар.....	
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ	
ДҮГНЭЛТ	11
ЗӨВЛӨМЖ	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НЗД	Нийслэлийн Засаг дарга
ДАА	Дотоод аудитын алба
НАЖГ	Нийслэлийн Аялал жуулчлалын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
УБ	Улаанбаатар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ННҮГ	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар

ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга (НЗД)-ын 2009 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр захирамжаар Нийслэлийн Аялал жуулчлалын газар (НАЖГ)-ыг 12 хүртэл албан хаагчтайгаар анх байгуулсан. 2019 оны А/241 дүгээр захирамжаар 18 албан хаагчтай, 2021 оны А/1059 дүгээр захирамжаар 18 албан хаагчтай байхаар, мөн НЗД-ын 2020 оны “Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай” А/283 дугаар захирамжийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр мэдээлэл, сурталчилгааны төвийн ажилтан 3, нийт 21 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



НЗД-ын 2022 оны А/155 дугаар захирамжаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийг баталсан. НАЖГ нь Засгийн газрын болон НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нийслэлийн Засаг даргаас аялал жуулчлалын талаар баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг мөн гэж заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байгууллага нь 5284325 улсын бүртгэлийн дугаартай, Төрийн сан банканд үндсэн үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийн гэсэн 2 харилцах данстай.

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг НЗД-н 2022 оны Б/34 дугаар захирамжаар дарга Д.Батсүх, хоёрдугаар гарын үсгийг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийг хүртэл нягтлан бодогч Д.Өнөржаргал, 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс нягтлан бодогч Д.Уянга нар тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Аудит хийх үндэслэл, бүрэлдэхүүн

Төсвийн тухай хуулийн 69.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр удирдамжийн дагуу Аудит, хяналт шалгалтын хэлтсийн дотоод аудитор Ц.Дуламдорж, дотоод аудитор Б.Солонгожаргал нар ажлын 20 хоногт аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Зорилго

Байгууллагын үйл ажиллагаа төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай хэр нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

Хамрах хүрээ

Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

- ✓ Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар
- ✓ Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

✓ Зорилт 3. Худалдан авах ажиллагааны талаар

Дотоод аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхдээ үндсэн үйл ажиллагаа, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцыг үнэлж, санхүүгийн тайлангууд, журнал, анхан шатны баримтуудыг хамруулан түүвэрчилсэн байдлаар сорил явуулж, тооцооллыг давтан шалгаж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, биет тест хэрэгжүүлэх зэрэг аудитын горимын дагуу нотлох баримт цуглуулан гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Өмнөх аудитын талаар:

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2022, 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан тул зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

Даргын зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 08 дугаар хурлаар Стратегийн төлөвлөгөө боловсруулаагүй, Засгийн газраас баталсан журмыг мөрдөж ажиллаагүй тухай Дотоод аудитын албанаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн боловч одоог хүртэл тус шийдвэр болон Дотоод аудитын зөвлөмж хэрэгжээгүй байна.

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар

Дүрмийн талаар:

НЗД-ын 2022 оны А/155 дугаар “Дүрэм шинэчлэн батлах тухай” захирамжаар газрын дүрмийг баталсан байна. Тус дүрэм 9 бүлэг, 22 зүйлтэй, аудит, хяналт шалгалтын хамраах хугацаанд дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллаж ирсэн байна.

Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Газрын даргын Хөдөлмөрийн дотоод журмыг 2022 оны А/66 дугаар тушаалаар шинэчлэн баталжээ.

Хөдөлмөрийн дотоод журмын 12.2.5 “Идэвх санаачилгатай ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн, мэргэжлийн ур чадвараараа хамт олноо манлайлсан албан хаагчийг жилийн эцэст сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар шагнах /Шилдэг ажилтан/” гэж заажээ. Шилдэг ажилтанд олгох шагналын хэмжээг сарын үндсэн цалинг хэд сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээтэй олгох тухай тодорхой зааж өгөөгүй байна. Үүнээс үүдэн 2022 онд шилдэг ажилтан шалгаруулж 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал, 2023 онд 2.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгосон байгаа нь ажилтан албан хаагчдын дунд тэгш бус байдлыг үүсгэжээ.

Даргын зөвлөлийн талаар:

НАЖГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар Даргын дэргэдэх зөвлөлийн даргаар Газрын дарга, гишүүдээр Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга нарийн бичгээр Хүний нөөц, ёс зүйн, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн томилон шинэчлэн зохион байгуулжээ.

Даргын дэргэдэх зөвлөл нь 2022 онд 15, 2023 онд 2 удаа тус тус хуралдаж, цаг үеийн шинжтэй асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэжээ. Журмын 1.10 “Даргын зөвлөлийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулна. Ажлын шаардлагаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.” гэж заасан нь 2022 онд 15, 2023 онд 2 удаа тус тус хуралдаж дээрх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүний нөөцийн талаар:

НЗД-ын 2021 оны А/1059 дүгээр захирамжийг үндэслэн тус газрын даргын 2022 оны А/03 дугаар тушаалаар албан хаагчдын ажлын байрны жагсаалтыг 18 албан хаагчтай

байхаар баталсан байна. 2022 оны эхэнд 17, 2020 оны эцэст 18 албан хаагч, 2021 онд 18 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хүснэгт 1

Хүний нөөцийн хөдөлгөөн

№	Үзүүлэлт	2022 он	2023 он
1	Ажлаас чөлөөлөгдсөн /өөрийн хүсэлтээр/	13	11
2	Шилжин явсан	-	1
3	Жирэмсний амралт	3	4
4	Томилогдсон албан хаагч	1	3
5	Байгууллага дотор өөр албан тушаалд шилжсэн	-	7

Тушаал шийдвэрийн талаар:

Тус газар нь 2022 онд А тушаал 72, Б тушаал 64, нийт 136, 2023 онд А тушаал 50, Б тушаал 85, нийт 135 тушаалыг гаргасан байна.

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын талаар:

Тус байгууллагад дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнгүй ба хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн жил бүр бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлийг тайлагнаж ажилладаг байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийх хяналт шинжилгээ үнэлгээний удирдамжийг жил бүр батлуулан ажилладаг боловч байгууллагын эрсдэлийг тооцож ажилладаггүй, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод дотоод хяналт шалгалт хийх чиг үүргийг тусгаагүй байна.

Ёс зүйн зөвлөлийн талаар:

Газрын даргын 2019 оны А/18 дугаар тушаалаар ЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолын дагуу хамт олны хурал хийж ёс зүйн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Ёс зүйн хорооны хурлын шийдвэрээр 2023 оны 6 дугаар сарын Б/41 дүгээр тушаалаар 1 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

НАЖГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд 267,240.2 мянган төгрөгийн эргэлтийн, 57,124.4 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 324,364.6 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

Хүснэгт 2.

Санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.01.01	2022.12.31	2023.12.31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	267,240.2	356,527.1	315,517.9
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4.8		
Авлага	34.0	634.2	
Урьдчилж гарсан зардал	94,201.8		
Бараа материал	172,999.60	355,892.9	315,517.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	57,124.4	80,620.3	164,269.7
Үндсэн хөрөнгө	57,124.4	80,620.3	164,269.7
Биет хөрөнгө	38,406.9	44,220.3	32,269.7
Биет бус хөрөнгө	18,717.5	36,400.0	132,000.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	324,364.6	437,147.4	479,787.7
ӨГЛӨГ	58.4		

ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	324,306.2	437,147.4	479,787.7
Засгийн газрын хувь оролцоо	324,306.2	437,147.4	479,787.7
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,000.0	60,000.0	60,000.0
Өмч: - төрийн	60,000.0	60,000.0	60,000.0
Хуримтлагдсан үр дүн	264,306.2	377,147.4	419,787.6
Өмнөх үеийн үр дүн	101,656.7	264,306.2	377,147.4
Тайлант үеийн үр дүн	162,649.5	112,841.2	42,640.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	324,364.6	437,147.4	479,787.7

НАЖГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгө 42,640.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тус онд биет бус хөрөнгө дансанд 101,700.0 мянган төгрөгийн газар орлого авсантай холбоотой байна.

Тайлант 2023 онд санхүүгийн байдлын тайланд 315,517.9 мянган төгрөгийн эргэлтийн, 164,269.7 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 479,787.6 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

Авлага:

ЧД-ийн НДХ-т НДШ илүү шилжүүлсэн тул 2022 онд 634.2 мянган төгрөг авлагаар тайлагнаж, 2023 онд тооцоо нийлж барагдуулсан байна.

Урьдчилж гарсан зардал:

НЗД-ын 2021 оны А/676 дугаар захирамжийн дагуу НЗДТГ нь Жи Эн Зэт Икс ХХК-тай Их тэнгэрийн аманд хадны зургийн орчныг тохижуулах нийт 134,573.9 мянган төгрөгийн ажлын гэрээг хийж 94,201.8 мянган төгрөгийг урьдчилж олгосон байсан. Уг ажил 2022 оны 11 сарын 29-нд ашиглалтад хүлээн авч үлдэгдэл төлбөрийг шилжүүлсэн байна.

Бараа материал:

Тайлант 2022 онд бараа материалын дансанд 342,953.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч 160,059.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, нийт 355,892.9 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

Хүснэгт 3

Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт		Тусгай зориулалтын материал	Бичиг хэргийн материал	Аж ахуйн материал	Сэлбэг хэрэгсэл	Түлш, шатах тослох материал	Хангамжийн материал	Дүн
2022 он	Эхний үлдэгдэл	114,031.5	1,185.7	3,334.7	2,104.2	1,600.0	50,743.5	172,999.6
	Нэмэгдсэн	184,538.8	2,000.6		1,229.5	20,900.9	134,283.4	342,953.2
	Хасагдсан	131,820.5	2,212.2	525.7	1,297.0	22,225.0	1,979.5	160,059.9
	Эцсийн үлдэгдэл	166,749.8	974.1	2,809.0	2,036.7	275.9	183,047.4	355,892.9
2023 он	Нэмэгдсэн	156,707.6	8,609.6		5,144.0	25,442.7	43,791.2	239,695.1
	Хасагдсан	199,657.0	8,106.2	250.0	5,144.0	25,640.2	41,272.6	280,070.0
	Эцсийн үлдэгдэл	123,800.4	1,477.5	2,559.0	2,036.7	78.4	185,566.0	315,518.0

Тайлант 2023 онд бараа материалын дансанд 239,695.1 мянган төгрөгийн орлого авч 280,070.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж 315,518.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна. Бараа материалын үлдэгдэл 40,374.9 мянган төгрөгөөр буурсан нь 92,464.4 мянган төгрөгийн хангамжийн материал актлаж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө:

Газрын даргын 2022 оны А/313 дугаар тушаалаар Жэжү олле нийгэмлэг, Койка ОУБ-ын сайн дурын төслийн 13 нэр төрлийн 17 ширхэг нийт 11,723.9 мянган төгрөгийн хөрөнгө

хандив тусламжаар хүлээн авч, Өөрийн хөрөнгөөр 27,299.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэн, нийт 39,023.8 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус данс бүртгэлд тусгасан байна.

Гэвч тус төслөөс 2023 онд хандив тусламжаар хүлээн авсан тус бүр 1472.4 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг зөөврийн компьютер биетээр байх боловч данс бүртгэл тусгаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5.1.4. “үнэн зөв байх;”, 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4

Үндсэн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

Огноо	Үзүүлэлт	Машин тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Бусад үндсэн хөрөнгө	Программ хангамж	Дүн
2022 он	Эхний үлдэгдэл	67,923.0	64,102.8	6,960.0	46,334.0	185,319.8
	Нэмэгдсэн	11,619.4	3,404.4		24,000.0	39,023.8
	Хасагдсан					-
	Эцсийн үлдэгдэл	79,542.4	67,507.2	6,960.0	70,334.0	224,343.6
2023 он	Нэмэгдсэн				106,700.0	106,700.0
	Хасагдсан	10,464.9	3,140.0		22,850.0	36,454.9
	Эцсийн үлдэгдэл	69,077.5	64,367.2	6,960.0	154,184.0	294,588.7
	Хуримтлагдсан элэгдэл	54,846.0	46,524.9	6,764.0	22,184.0	130,318.9
	Үлдэгдэл өртөг	14,231.5	17,842.3	196.0	132,000.0	164,269.8

НЗД-ын 2023 оны А/400 дугаар захирамжаар жуулчдад зориулсан “Визит Улаанбаатар” гар утасны аппликейшн хийлгэж 5,000.0 мянга, мөн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зориулалтаар НЗД-ын 2023 оны А/125 дугаар захирамжаар Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт 3000м2 газар олгосон тул 101,700.0 мянга нийт 106,700.0 мянган төгрөгийн хөрөнгө биет бус хөрөнгө дансанд бүртгэсэн.

НӨХГ-ын 2023 оны А/198 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй 18 нэр төрлийн нийт 36,454.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж данс бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй, НЗД-ын 2022 оны А/648 дугаар захирамжийн хүрээнд Сүүдэр Ай Эн Си ХХК-аар хийлгэсэн 24,000.0 мянган төгрөгөөр <https://cityofnomads.mn/> аппликэйшн хийлгэсэн боловч ашиглалтад орсны дараах хөгжүүлэлтийн зардлыг шийдвэрлээгүй тул аудитын хугацаанд ажиллахгүй байсан.

Төсвийн гүйцэтгэл:

НАЖГ нь 2022 онд орон нутгийн төсвөөс 342,825.7 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 65,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн нийт 407,825.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 333,516.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 37,872.1 мянган төгрөг төвлөрүүлж, 371,388.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 5

Төсвийн зарцуулалт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 он		2023 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	407,825.7	371,388.7	573,359.9	518,563.9
УРСГАЛ ЗАРДАЛ	407,825.7	371,388.7	573,359.9	518,563.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,559.7	367,329.3	568,359.9	513,631.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,382.4	259,349.0	422,345.8	379,462.7

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,774.3	33,673.6	55,565.3	49,364.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал			10,903.8	7,584.0
Хангамж, бараа материалын зардал	10,914.0	10,306.6	15,074.8	13,835.1
Бичиг хэрэг	1,466.0	1,464.7	2,566.0	2,723.7
Тээвэр, шатахуун	4,840.0	4,905.4	7,708.8	7,095.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,608.0	3,936.5	4,800.0	4,015.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,755.0	63,701.5	62,340.2	61,254.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,734.0	298.6	2,130.0	2,130.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,266.0	4,059.4	5,000.0	4,932.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,266.0	4,059.4	5,000.0	4,932.7
Төвлөрүүлэх шилжүүлэг				
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	373,901.2	350,118.1	377,745.6	360,239.5
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	407,825.7	371,388.7	573,359.9	518,563.9
Орон нутгийн төсвөөс	342,825.7	333,516.6	543,359.9	488,441.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	65,000.0	37,872.1	30,000.0	30,122.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000.0			
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.0	37,872.1	30,000.0	30,122.0

НАЖГ нь 2022 онд орон нутгийн төсвөөс 543,359.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 30,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэх нийт 573,359.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 488,441.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 30,122.0 мянган төгрөг төвлөрүүлж, 518,563.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого:

НЗД-н 2018 оны А/370 дугаар захирамжийн дагуу Сити тур төслийн хэрэгжүүлэхэд шаардлагатай 486,000.0 мянган төгрөгийн 2 автобусыг жилийн 4.5 хувийн хүүтэйгээр эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр НЗДТГ нь Ди Би Эм лизинг ХХК-тай 10 жилийн хугацаатай санхүүгийн түрээсийн гэрээ байгуулан худалдаж авсан. Ашиглалтын зардлыг НАЖГ хариуцан дотоодын иргэдийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор "Улаанбаатар сити тур" төсөл ажиллуулж байна.

"Улаанбаатар сити тур" төслийн тайлан

Сар	2022		2023	
	Аяллын тоо	Аялагчдын тоо	Аяллын тоо	Аялагчдын тоо
6	25	1191	9	634
7	13	502	22	1073
8	22	429	5	1307
9	34	2853	6	1535
10			3	503
Нийт дүн	94	4975	45	5052

Төслийн хүрээнд 2022 онд 94 удаагийн аялал зохион байгуулж, дотоодын болон гадаадын 4975 жуулчдад хот орчмын аялал зохион байгуулж, нийт 63,377.8 мянган төгрөгийн зардал гаргаж, нийслэлийн төсөвт 37,829.0 мянган төгрөг төвлөрүүлэн ажиллажээ.

Тайлант 2023 онд 45 удаагийн аялал зохион байгуулж, дотоодын болон гадаадын 5052 жуулчдад хот орчмын аялал зохион байгуулж, нийт 69,400.0 мянган төгрөгийн зардал гаргаж, нийслэлийн төсөвт 30,081.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Энэ нь байгууллагын дүрмийн "газрын үндсэн чиг үүрэг" бүлэгт газрын хийж хэрэгжүүлэх ажлын хүрээг НЗД-аас 15 үйл ажиллагааг эрхлэн явуулахаар тогтоож өгсөн боловч дүрэмд тусгагдаагүй үйл ажиллагаа болох "Сити тур" буюу хот дотор аялал зохион байгуулж, Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" заалттай нийцэхгүй байна.

Нэмэлт санхүүжилт:

Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах, жил бүр зохион байгуулагддаг аялал жуулчлалын үзэсгэлэн, явган аялал, шонхор шувууны наадам, УБ брэнд бэлэг тэмдэг мөн гадаадын аялал жуулчлалын гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, УБ хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа амралтын газар, жуулчны баазуудад стандарт үзлэг зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанд 2022 онд 910,737.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 891,259.7 мянган төгрөг зориулалтын дагуу зарцуулан, 19,447.7 мянган төгрөгийг НЗДТГ-ын 100200051001 дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 6

Нэмэлт санхүүжилт

/мянган төгрөгөөр/

№	Захирамж	Утга	Мөнгөн дүн
2022 он			
1	A/210	Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төв ажиллуулах тухай	23,643.4
2	A/460	"УБ трэвел экспо 2022" олон улсын жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай	20,000.0
3	A/493	УБ хотын аялал жуулчлалын сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	89,000.0
4	A/530	Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай /Унгарын соёл, аялал жуулчлалын өдрүүд, Хорека олон улсын тэмцээн/	61,994.3
5	A/531	Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай	54,319.9
6	A/648	Аян зохион байгуулах тухай	108,000.0
7	A/702	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг зохион байгуулах тухай	7,560.0
8	A/770	Талын салхи олон улсын мото наадам зохион байгуулах тухай	34,621.6
9	A/784	Плэйтийм олон улсын хөгжмийн наадам зохион байгуулах тухай	10,000.0
10	A/850	Дээлтэй монгол наадам зохион байгуулах тухай	45,000.0
11	A/838	Хөрөнгө гаргах тухай /их тэнгэрийн амны хадны зургийн орчны тохижилтын ажил/	40,372.2
12	A/993	Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай	31,600.0
13	A/1019	Хөрөнгө гаргах тухай /Даншиг наадам-Хүрээ цам/	42,522.5
14	A/1021	Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай /УБ үндэсний хоолны өдөрлөг, Шонхорын баяр, явган аяллын фестиваль/	45,974.0
15	A/1086	Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай /Сүүн зам соёлын наадам, Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд/	58,078.0
16	A/1135	Япон улсад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай	78,505.4
17	A/1162	УБ хотыг гадаадад сурталчлах ажлыг зохион байгуулах тухай	15,000.0
18	A/1181	Хийморь олон улсын морьт харвааны наадам зохион байгуулах тухай	18,011.5
19	A/1206	автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай	5,000.0
20	A/1323	"Ай Ти Эм 2022" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай	11,500.0
21	A/1324	УБ хотыг сурталчлах ажлыг цахим болон виртуал хэлбэрээр зохион байгуулах тухай	25,000.0

22	A/1	Уухай шагайн харвааны наадам зохион байгуулах тухай	11,199.9
23	A/1094	Олон улсын өвлийн аялал жуулчлалын өдрүүд зохион байгуулах тухай	51,588.5
24	A/1095	Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай	2,768.5
Дүн			891,259.7
2023 он			
1	A/43	Жуулчны мэдээллийн төв ажиллуулах тухай	93,418.5
2	A/25	Аялал жуулчлалын уулзалт, арга хэмжээ зохион байгуулах тухай	47,801.3
3	A/93	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах тухай	99,035.4
4	A/158	УБ хотыг олон улсад сурталчлах арга хэмжээг зохион байгуулах тухай	38,655.2
5	A/400	Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай	79,727.5
6	A/418	Хятад улсад зохион байгуулагдах олон улсын хуралд оролцох	6,620.0
7	A/419	"УБ трэвел экспо 2023" олон улсын жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай	35,664.6
8	A/420	Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай	44,386.3
9	A/421	Плэйтийм олон улсын хөгжмийн наадмын урьдчилсан эвент зохион байгуулах тухай	16,460.0
10	A/545	Талын салхи олон улсын мото наадам зохион байгуулах тухай	56,500.0
11	A/558	Павер экспо авто фестиваль зохион байгуулах тухай	49,251.9
12	A/676	Плэйтийм олон улсын хөгжмийн наадам зохион байгуулах тухай	20,000.0
13	A/530	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг зохион байгуулах тухай	400.0
14	A/718	Үйлчилгээний ажилчдын гарын авлага бэлтгэж түгээх	19,500.0
15	A/859	Даншиг наадам хүрээ цам зохион байгуулах	174,022.6
16	A/890	Арга хэмжээ зохион байгуулах тухай	81,650.0
17	A/982	УБ олон улсын явган аяллын фестиваль зохион байгуулах	35,565.9
18	A/983	Аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулах	79,076.6
19	A/996	Гадаад томилолтын тухай	4,340.6
20	A/1043	Хийморь олон улсын морьт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах тухай	86,087.0
21	A/1044	УБ хотыг гадаадад болон цахим орчинд сурталчлах ажлыг зохион байгуулах тухай	45,345.8
22	A/1242	Нийслэл хот байгуулагдсаны 384 жилийн ойн өдрийг тохиолдуулан арга хэмжээ зохион байгуулах	5,700.0
23	A/716	Дээлтэй монгол наадам зохион байгуулах тухай	35,000.0
Дүн			1,153,608.1

Нэмэлт санхүүжилтийн дансанд НЗД-ын захирамжийн дагуу зохион байгуулагдсан арга хэмжээнд 2023 онд 1,176,984.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,153,608.1 мянган төгрөг зарцуулан, 23,375.9 мянган төгрөгийг НЗДТГ-ын 100200051001 дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Зорилт 3. Худалдан авах ажиллагааны талаар

Уб хот орчмын түүх соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулах үнэлгээний хороо 2022 онд а/06 дугаар тушаалаар байгуулан цахим тендер зарлан 1 ААН санал ирүүлж, шаардлага хангасан тул шалгаруулан Өндөр Хаан өргөө ХХк-тай 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдөр НХААГ/202212090 дугаар гэрээ байгуулсан. Уг ажлыг 2022 оны 11 сарын 29-нд хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Эвент арга хэмжээ, сурталчилгааны материал хэвлүүлэх зэрэгт хамтран ажиллах 65 байгууллагаас үнийн санал авч, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажилласан байна.

Санхүү, бүртгэлийн үйл ажиллагааны талаар:

Тус байгууллагын санхүү нь ННҮГ-ын агентлаг хариуцсан нягтлан бодогч 1, нярав 1 гэсэн бүрэлдэхүүнтэй, 2020 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн тайлагналын Accoulus программыг ашиглан тайлан тооцоогоо гаргаж байна.

Тайлант онуудын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус газрын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс жилийн болон хагас жилийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, тооцоог бодон, санхүүгийн тайланд тусгасан. Өмч эзэмшигчийн карт хөтөлж, эд хөрөнгийг холбогдох хүмүүст хариуцуулан ажилласан байна.

Ололттой тал:

Тайлант онуудын санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгыг харьяалагдах байгууллагад хуулийн хугацаанд нь хүргүүлж ажилласан байна. Албан хаагчдын цалин хөлсийг холбогдох хууль, заавар журамд нийцүүлэн тооцож, цаг хугацаанд нь олгож иржээ. Мөн цалин хөлснөөс суутгах суутгалуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцон цаг хугацаанд нь шилжүүлж, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ийн болон бусад өр төлбөргүй ажилласан байна.

Дутагдалтай тал:

Байгууллагын дарга нь тушаал гаргахдаа холбогдох хууль тогтоомжийн төсвийн шууд захирагчийн эрхийг хэрэгжүүлээгүй, НЗД-ын эрхийг үндэслэл болгосон байна. Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3.1.3. Байгууллагын удирдлага хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах зорилгоор зохион бүрдүүлсэн захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл-лавлагааны баримт бичгийг баталгаажуулна. заалтад нийцэхгүй байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийх хяналт шинжилгээ үнэлгээний удирдамжийг жил бүр батлуулан ажилладаг боловч байгууллагын эрсдэлийг тооцож ажилладаггүй, мөн санхүү, худалдан авах ажиллагаа өмч хамгааллын үйл ажиллагаануудад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Жэжү олле нийгэмлэг, Койка ОУБ-ын сайн дурын төслийн 2023 онд хандив тусламжаар хүлээн авсан тус бүр 1472.4 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг зөөврийн компьютер биетээр байх боловч данс бүртгэл тусгаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай

хуулийн 5.1.4. "үнэн зөв байх";, 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" заалт, Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаал "Хандив тусламжийг бүртгэх журам"-ыг хэрэгжүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэн ажиллаж, удирдлага, санхүүгийн ажилтнууд нь 2022 он, 2023 онд санхүүгийн байдал, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад тодруулгыг холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журам, эрх зүйн актын дагуу тайлагнасан байна.

Байгууллагад мөрдөгдөж байгаа журмын зүйл заалтууд хоорондоо зөрчилдөж байна. Мөн даргын тушаал шийдвэр гаргахдаа хуулийн хүрээнд өөрийн эрх хэмжээг тусгасан заалтуудыг үндэслэх, санхүү, худалдан авах ажиллагаа, өмч хамгааллын үйл ажиллагаануудад дотоод хяналтыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

НДАА-аас НАЖГ-ын 2022 он, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтаар байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 2,944.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, цаашид давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

Дотоод аудитын хяналт шалгалтаар танай байгууллагад "Хангалттай" гэсэн дүгнэлт өгч байна.

ЗӨВЛӨМЖ

Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн асуудалд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Даргын тушаалын үндэслэх хэсэгт холбогдох хууль тогтоомжид байгууллагын даргын эрх хэмжээг тусгасан заалтыг үндэслэж байх;
2. Төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлыг нарийн төлөвлөж зориулалтын дагуу зарцуулж, үр ашиггүй зардал гаргахгүй байх, аппликейш ашиглалтад орсны дараах хөгжүүлэлтийн зардлыг төсөвт тусган, бүрэн ашиглах
3. Санхүү, худалдан авах ажиллагаа, өмч хамгааллын үйл ажиллагаануудад дотоод хяналт шалгалт зохион байгуулж ажиллах

Зөвлөмжийг хэрэгжүүлж хэрэгжилтийн тайланг нийслэлийн Дотоод аудитын албанд 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлэхийг мэдэгдэж байна.

ХЯНАСАН:

ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН
ҮҮРЭГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БЭЛТГЭСЭН:

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДОТООД АУДИТОР
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДОТООД АУДИТОР /СХШУБ/ Б.СОЛОНГОЖАРГАЛ
ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ



Д.БАТСҮХ

Д.УЯНГА



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 он

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 04 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 01 дүгээр удирдамжийн дагуу Нийслэлийн Дотоод аудитын албанаас тус газрын 2022, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулан үйл ажиллагаанд хэрэгжүүлж дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:

1. Даргын тушаалын үндэслэх хэсэгт холбогдох хууль тогтоомжид байгууллагын даргын эрх хэмжээг тусгасан заалтыг үндэслэсэн байх,

1.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг "Аймаг, сум, нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газрын дарга, засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ." гэж заасан зүйл, заалтын хүрээнд байгууллагын даргын тушаалын үндэслэл хэсэгт холбогдох хууль тогтоомжид заасан даргын эрх хэмжээг тусгасан заалтыг үндэслэж, тушаалын төсөлд нэгжийн дарга нар тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

1.2. Байгууллагаас 2024 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 37, хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлээр 45 нийт 82 тушаал шийдвэр батлан 2025 оны эхний 4 сарын байдлаар байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 14 тушаал, хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлээр 15 тушаал буюу нийт 29 тушаал, шийдвэр холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлан гаргаж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн эрх зүйн мэдээллийн сан www.ublegal.ulaanbaatar.mn цахим хуудаст бүртгэл үүсгэн ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУРЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 04 өдөр Дугаар А/160 Улаанбаатар хот

2024 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийх комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 73 дугаар зүйл, Нийслэл бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Тус газрын үндсэн эд хөрөнгө, материалын 2024 оны хагас жилийн тооллого хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
	Маркетинг, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
	Дотоодын аялал хариуцсан мэргэжилтэн
	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
	Архив, бичиг хэргийн эрхлэгч
Нарийн бичгийн дарга:	Жуулсны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежер

2. Тооллогын комиссын гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА Д.ГАНБОЛД Д.БАТСҮХ

ГБХА/О 2024А Тушаалын төсөл 2024.05.20 А/4-дос

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУРЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 05 өдөр Дугаар А/160 Улаанбаатар хот

Албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 67 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 487 дугаар, 2023 оны 240 дугаар, 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 10 дугаар хавсралт, 11 дүгээр хавсралтууд, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Монгол Улсын Засгийн газраас төрийн албаны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан газрын албан хаагчдын үндсэн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан албан хаагчдын цалинг сар бүр тогтмол олгож байхыг Агаарлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Б/02 дугаар тушаалын хавсралтаар баталсан албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг тогтоосон хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Д.ГАНБОЛД Д.БАТСҮХ

ГБХА/О 2024Б Тушаалын төсөл 2024.04.04 Б/02-дос

1150500053

2. Төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлыг нарийн төлөвлөж зориулалтын дагуу зарцуулж, үр ашиггүй зардал гаргахгүй байх, аппликейш ашиглалтад орсны дараа дараах санхүүжилтийн зардлыг төсөвт тусган, бүрэн ашиглах

2.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4 "үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлж төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлыг төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж, үр ашиггүй зардал гаргахгүй ажиллаж байна.

3. Санхүү, худалдан авах ажиллагаа, өмч хамгааллын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулж ажиллах

3.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" зүйл, заалт болон Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаалаар батлагдсан "Хандив тусламжийг бүртгэх журам"-ын хүрээнд "Жэжү Оллэ Койка" байгууллагын сан дурын төслөөс хандив, тусламжаар хүлээн авсан 2,944,810 (хоёр сая есөн зуун дөчин дөрвөн мянга найман зуун арав) хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгийн данс бүртгэлд бүртгэх зөвшөөрөл олгох хүсэлтийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлж, орлогод бүртгэсэн.


НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
Хайрханын талд байрлалын IV байр,
Ж.Сэнгүүгийн талбайн 4 дүгээр хороо,
Монгол улс, Улаанбаатар хот-15160
Утас/факс: (071) 7113667
Цалин суурин: info@ajl.gov.mn
Цалин хуудас: info@ajl.gov.mn

2024.05.28 № 02/214
Хүсэлт гаргах тухай

Тус газарт "Жэжү Оллэ Койка" байгууллагын сайн дурын төслөөс хандивласан 1 төрлийн 2 ширхэг 2,944,810 (хоёр сая есөн зуун дөчин дөрвөн мянга найман зуун арав) төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэх зөвшөөрөл олгоно уу.

1 дугаар хавсралт: Хандиваар авсан хөрөнгийн жагсаалт, 2 хуудастай.
2 дугаар хавсралт: Зураг, 1 хуудастай.
3 дугаар хавсралт: Хурлын тэмдэглэл, 2 хуудастай.

Нийслэлийн аялал жуулчлалын газар
Харилцаа
Дарга
Дэлгэрмэц Батсүх
2024.05.29 15:57

Орлогын баримт № 3

2022.05.18, үр 23, 400

Жэжү Оллэ Койка

№	Материал үнэт зүйлсийн нэр, хэрэг, дугаар	Код	Хэмжээ юмж	Нэг бүрийн үнэ	Хүлээн авсан	
					Төл	Дүн
1	Хандив хандиваар авсан	00001115	м	1,472,493.00	2.00	2,944,986.00
2	Хандив хандиваар авсан	00001116	м	1,500,000.00	1.00	1,500,000.00
3	Хандив хандиваар авсан	00001117	м	210,000.00	1.00	210,000.00
4	Хандив хандиваар авсан	00001118	м	940,000.00	1.00	940,000.00
5	Хандив хандиваар авсан	00001119	м	400,000.00	1.00	400,000.00
	Дүн				8.00	6,179,000.00

Хүлээн авсан: Д.Улам
(Тусгай) Хүлээн авсан: /
Шалгах нөхцөл: /

3.2. Нийслэлийн Өмчийн харилцааны газартай "Нийслэлийн өмч эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулж гэрээний биелэлтийн ханган Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалаар байгууллагын 2024 оны эд хөрөнгийн тооллого зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн программ дах дансанд бүртгэлтэй тулган тооллогоор 192 нэр төрлийн 34,000 ширхэг 306,588,631.00 төгрөгийн үндсэн хөрөнгө, 286 төрлийн 117,250,958.45 төгрөгийн бараа материалд тооллого явуулж тайлан мэдээг хугацаанд нь Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүллээ.

3.3. Байгууллагын 2024 оны төсөвт бичиг хэргийн зардалд 1,466,000 төгрөг, тээвэр шатахууны зардалд 16,896,000 төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 5,160,000 төгрөг нийт 23,522,000 батлагдаж 2024 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар бичиг хэргийн зардалд 1,001,460 төгрөг, тээвэр шатахууны зардалд 6,273,500 төгрөг, шуудан

холбоо, интернэтийн төлбөрт 1,963,465.02 төгрөг нийт 9,238,425.02 төгрөг зарцуулж санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж санхүүгийн тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь тайлагнаж, шинээр авлага, өр төлбөр үүсгээгүй, он дамжсан, насжилт өндөртэй өр, авлага үүсгээгүй ажиллаж төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг www.info.shilendans.gov.mn цахим санд туай бүр байршуулсан.

3.4. Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 2024 онд 1 төсөл, арга хэмжээний буюу Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/476 дугаар захирамжаар Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Аялал жуулчлалын газарт шилжүүлсэнтэй холбогдуулан НХААГ/20240101317 дугаартай худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн амжилттай зохион байгуулсан.

ТАНИЛЦСАН:
ДАРГА




Д.БАТСҮХ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛЖ НЭГТГЭСЭН:
АХЛАХ НЯГТЛАН
БОДОГЧ



Д.МӨНХГЭРЭЛ

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН


О.НЯМБАТ